



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын нэр: Санхүүгийн дотоод аудит

Хамрагдсан байгууллага: Дорнод аймгийн музей

Тайлангийн код: ХШҮДАГ-2025/ДА/21

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР1

1.ТАНИЛЦУУЛГА.....2

1.1. Байгууллагын тухай2

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ3

2.1. Аудитын зорилго:.....3

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт.....3

2.3. Аудитын арга, аргачлал3

2.4. Өмнөх шалгалтын талаар4

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ.....5

3.1. Засаглалын удирдлагын талаар5

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар.....6

3.3. Дотоод хяналтын талаар.....6

4. Санхүүгийн үйл АЖИЛЛАГААНЫ талаар.....6

5. АУДИТЫН ҮР ДҮН.....8

5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.8

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.....8

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр9

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ.....10

7. ЗӨВЛӨМЖ.....10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХШУДАГ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1. ТАНИЛЦУУЛГА

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 7.2, 7.3, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, сайдын дэргэдэх “Дотоод аудитын хорооны 2025 оны төлөвлөгөө”, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/76 дугаар тушаалаар баталсан “Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, дотоод аудит хийх” удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ХШУДАГ-ын дарга Д.Түмэндэмбэрэл ахалж, тус газрын ахлах шинжээч Ц.Алтанхуяг, гэрээт дотоод аудитор О.Пүрэвсүх нар Дорнод аймгийн Музейн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгэлээ.

1.1. Байгууллагын тухай

Дорнод аймгийн музей анх 1950 онд байгуулагдсан. Тухайн үед орон нутаг судлах кабинет нэртэй байсан бөгөөд 1967 – 1998 онд Орон нутаг судлах музей, 1999 онд Дорнод аймгийн музей болон өргөжсөн. Эдүгээ музейн сан хөмрөг нь 4000 гаруй үзмэртэй. [Дорнод аймгийн](#) музей нь Халхын сэцэн хан аймгийн үеэс өнөөгийн Дорнод нутгийн түүх соёл, ард түмний ахуй амьдрал, зан заншил, ололт амжилтыг харуулсан үзмэрээр музейн сан хөмрөгөө баяжуулсаар байна. Түүх угсаатны музей, Уран зургийн галерей, Байгалийн түүхийн музей, Жуковын музей гэсэн 4 хэсэгт төрөлжүүлэн 26 танхимтайгаар үйл ажиллагаагаа явуулдаг. Түүх угсаатны музей нь Дорнод аймгийн танхим, генералуудын танхим, пионерийн танхим, Ц.Дамдинсүрэнгийн танхим, Х.Чойбалсангийн танхим, То Вангийн танхим, барга танхим, үзэмчин танхим, буриад танхим, үнэт эдлэлийн танхим, шашны танхим, ахуйн хэрэглээний танхим, малчин монгол танхим, уран зургийн галерей 1-3, социализмын танхим, театрын танхим, гадаад харилцааны танхим, боловсролын өрөө гэх мэт танхимд үзмэр дэглэжээ.

Одоогийн Чойбалсан хот буюу Санбэйсийн хүрээний зураг нь музейн үнэт үзмэрийн нэг бөгөөд тус хүрээг 1910 – 1922 онд Ачит сан бэйс Сансрайдорж ноён захирч байжээ. Эл зургийг 1966 онд зураач Д.Гомбосүрэн бүтээжээ. Тус музейд маршал Х.Чойбалсангийн пельник, ХҮИИ – XIX зууны үеийн цэрэг эрийн саадаг, хоромсог, худрага, хазаар, хөмөлдөрөгө, 1895 онд Хөх хотод дархан Дагва, Жан-ай-лоу нарын хүрлээр цутгаж бүтээсэн 500 литр багтаамжтай Жасын хүрэл тогоо зэрэг түүхэн үнэт үзмэрүүд бий.

Байгалийн музейн ан амьтны хэсэгт мөлхөгч амьтад, жигүүртэн шувууд, хоёр нутагтан, шавьж, тал нутгийн хөхтөн амьтад, нэн ховордсон буган хандгай, буга, бор гөрөөс, бүргэд, тогоруу, загас, мөн эмийн ургамлыг байгаль дахь орчинтой нь хамт дэглэн харуулжээ.

Тус байгууллага нь Аймгийн Засаг даргын 2024 оны 06 дүгээр сарын 11-ны өдрийн А/312 дүгээр захирамжаар бүтэц орон тоог 38 ажилтантай байхаар шинэчлэн батлуулсан.

Байгууллагын регистрийн дугаар 9030638, үндсэн үйл ажиллагааны 100070035021, орон нутгийн төсвөөс санхүүжих 100070035010, ахмадын сангийн 100070035501 тоот харилцах дансаар бэлэн, бэлэн бус төлбөр тооцоог хийж иржээ.

Аймгийн Засаг даргын 2022 оны 02 дүгээр сарын 21-ны өдрийн Б/08 дугаар захирамжаар В.Нарангэрэл Дорнод аймгийн музейн захирлыг албан тушаалд томилсон байна. Аудитын хамрах хугацаанд дээрх шийдвэрийн дагуу нэгдүгээр гарын үсгийг

В.Нарангэрэл одоог хүртэл, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогчоор 2012 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар томилогдсон Л.Эрдэнэсүвд нар тус тус зурж хөрөнгө, мөнгийг захиран зарцуулжээ.

Тус байгууллага нь 2024 оны жилийн эцсийн болон 2025 оны хагас болон III улирлын санхүү, татвар, нийгмийн даатгалын тайлангуудыг хуулийн хугацаанд нь холбогдох байгууллагуудад гарган өгч баталгаажуулсан.

Бүтэц зохион байгуулалт

Байгууллага нь захиргаа аж ахуй -19, Арга зүйч-4 орон тоотой, 2 нэгжтэй ажиллаж байна.

Засаглах удирдлага: Аймгийн музей сангийн үлгэрчилсэн дүрмийн 2.2-д аймгийн музей нь орон тооны бус мэргэжлийн зөвлөлтэй байж болох тухай заалтын дагуу захирлын дэргэд 2 зөвлөл ажиллаж байна. Үүнд: 2025 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/08 тушаалаар “Баримт бичгийг нягтлан шалгах комисс”, 2025 оны 08 дүгээр сарын 20-ны “Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулах тухай” А/09 дугаар тушаалаар зөвлөл, дэд хороо тус тус байгуулагдсан байна.

2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1. Аудитын зорилго:

Тус байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийн дүгнэж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах, зөвлөмж өгөх байдлаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилго баримтлан ажилласан.

2.2. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Хамарсан хүрээ: Тус байгууллагын 2025 оны III улирлын байдлаар тасалбар болгон санхүүгийн үйл ажиллагаа (засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, төсөв, санхүүгийн бүртгэл тооцоо, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр)-нд байдалд санхүүгийн дотоод аудитыг гүйцэтгэсэн.

Хязгаарлалт: Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар нь тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүгийн аудит хийж “Хязгаарлалттай дүгнэлт” байна. Тус тайлангийн хамарсан хүрээгээр энэхүү хяналт шалгалтыг хязгаарласан болно.

2.3. Аудитын арга, аргачлал

Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар баталсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”, Соёлын сайдын /хуучин нэрээр/ 2022 оны А/118 дугаар тушаалаар баталсан “Дотоод аудитыг гүйцэтгэх аргачлал”-ыг мөрдөж санхүүгийн аудитыг гүйцэтгэсэн болно.

Аудитад дараах хууль эрх зүйн актуудыг шалгуур болго. Үүнд:

- ✓ Төрийн албаны тухай хууль;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай;
- ✓ Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- ✓ Төрийн аудитын тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Шилэн дансны тухай хууль;
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль;
- ✓ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- ✓ Соёлын тухай хууль;
- ✓ Музейн тухай хууль;
- ✓ Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хууль;
- ✓ Бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт.

2.4. Өмнөх шалгалтын талаар

Тус байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар санхүүгийн аудит хийж гүйцэтгэсэн. Аудитын дүнгээр 7 нэр төрлийн алдаа зөрчил илэрч төлбөрийн акт -2, албан шаардлага -4, зөвлөмж -1 ийг хүргүүлсний хэрэгжилтийг хянахад биелэлт 100 хувьтай байна.

Дорнод аймгийн Төрийн аудитын газар 2025 оны эхний хагас жилд завсрын аудит хийж гүйцэтгэн 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 667 тоот албан бичгээр алдаа зөрчилтэй асуудал гараагүй тухай мэдээлэл ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийн дүн

Шийдвэрийн төрөл	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн товч утга	Мөнгөн дүн мян төг	Хэрэгжүүлсэн байдал
Төлбөрийн акт	Ажилчдын удаан жил ажилласан нэмэгдлийг дутуу тооцоолон олгосон	549.9	ажилчдын удаан жилийн нэмэгдлийг бүрэн барагдуулсан
Төлбөрийн акт	Байгууллагын удирдлагад Аймгийн засаг даргын 2024.12.18-ны Б/58 дугаар захирамжаар шагнал, урамшууллыг 100 хувь, Аймгийн засаг даргын 2024.12.24-ны Б./67 дугаар захирамжаар 150 хувиар давхардуулан олгосон	2,431.5	Байгууллагын удирдлагад 2,431,5 төгрөгийн нэмэгдэл, урамшуулалыг Аймгийн Засаг даргын захирамжаар давхардуулан олгосон зөрчлийн 1,100.0 мянган төгрөгийг 2025 оны 5-н сард төлсөн. Үлдэгдэл 1,331.5 мянган төгрөгийг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр бүрэн барагдуулсан.
Албан шаардлага	Байгууллагын бүртгэл дэх бүх мал амьтадыг зуданд өртөж данснаас хасахдаа эрх бүхий албан тушаалтны шийдвэр, актыг үйлдээгүй	7,125.0	байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй мал амьтадын зарлагын баримтыг эрх бүхий байгууллагаас нөхөн бүрдүүлж ажиллаа.
Албан шаардлага	Албан хаагчдад олгох тэтгэмжийн тушаалын хавсралтад байгууллагын удирдлагын нэр байхгүй байхад 2 удаа олгож залруулга хийсэн	194.6	Дээрх алдаа дутагдалыг дахин давтахгүй, хавсралт материалын иж бүрдлийг тулган хяналтаа сайжруулан ажиллана.

Зөвлөмж	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй бүртгэл мэдээллийн санчийн програм, хуучин санхүүгийн програмыг данснаас хасаагүй байна	4,410.0	Байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 4,000.0 мянган төгрөгийн программ хангамжийг цаашид ашигдахгүй тул байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хуралдаад хуралдаад 2025 оны эхний хагас жилээр бүртгэлээс хасч, мөн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй цаашид ашиглахгүй 410.0 төгрөгийн санхүүгийн программыг Дорнод аймгийн Иргэдийн Хурлын тогтоолын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 05-01/03-ны өдрийн 2 дугаар хавсралтаарыг үндэслэн ту тус данснаас хассан
Албан шаардлага	Бараа материалд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг бүртгэсэн	25,758.0	Байгууллагын эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 7-н нэр төрлийн 66 ш 25,758.0 мянган төгрөгийн эд хөрөнгөөс цаашид ашиглах боломжгүй, орой хэсэг нь урагдсан, холбоос төмөр баганагүй болсон 1 ширхэг 3,000.0 мянган төгрөгийн үнэтэй асарыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэн хурлын тэмдэглэлийг үндэслэн музейн захиралын 2025 оны А/16 тоот тушаалаар бүртгэлээс хасч, бусад 6-н нэр төрлийн 65-н ширхэг 22,758.0 мянган төгрөгийн эд хөрөнгийг зохих журмын дагуу үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд бүртгэж авлаа.
Албан шаардлага	Нийт 6 ажилтнаас ибаримтын нэхэмжлэх шивүүлж нийт 17.2 сая төгрөгийн шилжүүлэг хийсэн ба тус зардлуудтай холбогдох анхан шатны баримт хавсаргаагүй, худалдан авсан 14.3 сая төгрөгийн хөрөнгөд худалдах худалдан авах гэрээ хийгээгүй, тухайн хөрөнгийн дагалдах бичиг баримтыг бүрдүүлээгүй	17,230.9	Дээрх алдаа зөрчлийг дахин давтахгүй бараа материал худалдан авахдаа анхан шатны материалыг тухай бүрд нь бүрдүүлж, худалдан авалт хийж байна.
Дүн		57,699.5	

3. ЗАСАГЛАЛ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТӨЛӨВШИЛ

3.1. Засаглалын удирдлагын талаар

Хөдөлмөрийн дотоод журмын талаар:

Байгууллагын захирлын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А/12 тушаалаар “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг баталсан байна.

Тушаал шийдвэрийн талаар:

Тус байгууллага нь 2025 оны эхний улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны чиглэлээр “А” индексийн 23, боловсон хүчний чиглэлээр “Б” индексийн 27, нийт 50 тушаал төлөвлөж гаргасан байна.

Байгууллагын засаглалын талаар ажлын баримт АБ1002-оор ерөнхий 3 асуултын хүрээнд 7 дэд асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Давтамжтай буюу 2-р түвшин”-нд байна

3.2. Эрсдэлийн удирдлагын талаар

Тус байгууллага нь эрсдэлээ тодорхойлж, үнэлдэггүй.

Байгууллагын эрсдэлийн удирдлагын үйл явцын талаар ажлын баримт АБ1003-аар 12 асуулга авч, дотоод аудитын аргачлалд заасан 8 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

3.3. Дотоод хяналтын талаар

Дотоод хяналтын тухайд байгууллагын үндсэн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайлагнасан, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Байгууллагын дотоод хяналтын 2025 оны төлөвлөгөөнд 10 арга хэмжээ төлөвлөсөн. Дотоод хяналтын үйл явцын талаар ажлын баримт АБ1004-өөр 8 асуулга авч дотоод аудитын аргачлалд заасан 4 чиглэлийн 13 шалгуураар үнэлгээ хийхэд төлөвшил нь “Эхлэлийн буюу 1-р түвшин”-нд байна.

4. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Төсвийн төлөвлөлт

Байгууллагын 2025 оны төсвийн төслийг 1,054,732.1 мянган төгрөгөөр боловсруулан ССАЖЗЯ - нд хүргүүлсэн.

ССАЖЗЯ - аас тус байгууллагын 2025 оны төсвийг 716,226.1 мянган төгрөгөөр анх баталсан боловч 2025 оны 7 дугаар сард хийгдсэн төсвийн тодотголоор 677,369.9 мянган төгрөг болж 38,856.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Тус байгууллагын 2025 оны урсгал санхүүжилтэд улс, орон нутгийн төсвөөс 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 606,777.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

- Үндсэн үйл ажиллагааны зардалд 505,421.6 мянган төгрөг
- Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зардалд 17,350.7 мянган төгрөг
- Байр ашиглалтын зардалд 47.9 сая төгрөг
- Үндсэн үйл ажиллагааны орлого 32,734.8 мянган төгрөг

Тус байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,848,130.5 мянган төгрөгөөр буюу 0.12 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,780.0	59,414.9	53,634.9
Авлага	6,000.0	0	-6,000.0
Бараа материал	73,931.8	42,698.8	-31,233.0
Үндсэн хөрөнгө	1,764,818.2	1,746,016.8	-18,801.4

Нийт хөрөнгө	1,850,530.0	1,848,130.5	-2,399.5
Богино хугацаат өр төлбөр	4250.9	4250.9	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,846,279.1	1,843,879.6	-2,399.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,850,530.0	1,848,130.5	-2,399.5

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 53,634.9 мянган төгрөг байна. Энэ нь Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 31,233.0 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 26,464.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авч, 57697.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,746,016.8 мянган төгрөг болж 18,801.4 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тайлант хугацааны 23,508.0 сая төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө орлого авч, тайлант хугацаанд 410.0 мянган төгрөгийн актласан, 42,309.3 мянган төгрөгийн цэвэр элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлгүй. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,843,879.6.0 мянган төгрөг болж, 2,399.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 2025 оны III улиралд улс, орон нутгийн төсвөөс 587,614.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харуулав.

Байгууллагын 2025 оны III улирлын байдлаарх төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүн

№	Орлого, зардлын эдийн засгийн ангилал	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
I	НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	606,777.1	587,614.4	19,162.7	96.8
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	500,421.6	500,421.6	0.0	100.0
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны аж	5,000.0	5,000.0	0.0	100.0
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	17,350.7	17,350.7	0.0	100.0
83603	Үндсэн үйл ажиллагааны орлого	32,734.8	32,734.8	0.0	100.0
80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	47,900.0	47,900.0	0.0	100.0
II	НИЙТ ЗАРДАЛ	606,777.1	587,614.4	19,162.7	96.8
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл ура	470,832.8	470,349.5	483.3	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатга	59,560.9	59,560.9	0.0	100.0
210301	Гэрэл, цахилгаан	26,800.0	17,059.3	9,740.7	63.7
210302	Түлш, халаалт	10,000.0	2,000.0	8,000.0	20.0
210303	Цэвэр, бохир ус	1,100.0	245.6	854.4	22.3
2106	Эд хогшил, урсгал засварын зар	1,000.0	1,000.0	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	750.0	749.9	0.1	100.0
210402	Тээвэр, шатахуун	450.0	450.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэт	750.0	750.0	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	0.0	0.0	0.0	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх,	900.0	899.9	0.1	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000.0	1,000.0	0.0	100.0

210702	Дотоод албан томилолт	1,500.0	1,494.0	6.0	99.6
210802	Аудит бат, зэрэглэл тогтоох	2,016.0	2,016.0	0.0	100.0
210807	Газрын төлбөр	5,006.7	4,968.9	37.8	99.2
210901	Бараа үйлчилгээний бусад зарда	1,600.0	1,593.3	6.7	99.6
210801	Эрдэм шинжилгээ, судалгааны зардал	5,000.0	4,999.5	0.5	100.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах тэтгэмж	0.0	0.0	0.0	
	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн нэгдсэн зарцуулалт	17,930.7	17,897.6	33.1	99.8
210104	Урамшуулал	2,313.4	2,312.4	1.0	100.0
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	289.2	260.0	29.2	89.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,940.3	6,940.0	0.3	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зарда	5,205.2	5,205.2	0.0	100.0
213204	Ажил олгогчоос олгох тэт, урам	2,602.6	2,600.0	2.6	99.9
210801	Дээд шатны төсвөөс хуваарилсан дэмжлэгийн зарцуулалт	580.0	580.0	0.0	100.0

5. АУДИТЫН ҮР ДҮН

5.1. Засаглал, дотоод хяналт, нийтлэг мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар.

Илэрсэн асуудал 1. Дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй байна.	
Дотоод аудитын хамарсан хүрээ: Засаглал, эрсдэлийн удирдлагын төлөвшлийг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үр нөлөөг үнэлэх.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.3. Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна.	Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу удирдамж батлан хяналт шалгалтыг гүйцэтгээгүй, дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна;
Шалтгаан	
Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар албан тушаалтны үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.	
Дүгнэлт:	
Байгууллагын үндсэн үйл ажиллагаа, төсөв санхүүгийн зарцуулалтад удирдамжийн дагуу дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.	
Зөвлөмж:	
1. Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;	

5.2. Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр.

Илэрсэн асуудал 1. Хавсран түр орлон гүйцэтгэгчийн нэмэгдэл хөлсийг илүү олгосон байна.
Дотоод аудитын чиглэл: Бүтэц орон тоо, цалин тогтоолт, бодолт, олголт, цалингаас суутгасан ХХОАТ, НДШ –ийн өр, авлагын бүртгэл хөтлөлтийг хянаж үр нөлөөг үнэлэх.
Нөхцөл байдал: Байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн Б/03 тоот тушаалаар хүний нөөцийн ажилтан М.Болор-Уянгыг архив бичиг хэргийн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлэхээр тушаал

гаргахдаа хавсран гүйцэтгэх албан тушаалын цалинг үндсэн ажлын буюу хүний нөөцийн албан тушаалын ТҮ-7 1,340,000 төгрөгөөс 40 хувь бодож олгохоор гаргасан байна. Тус тушаалын дагуу нягтлан бодогч 2-10 сар хүртэлх нийт 9 сарын хугацаанд 205,2 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Мөн жижүүр ажилтай С.Баттайван, Г.Гансүх нарыг 2025 оны 10 дугаар сарын 01-нээс галчын ажлыг хавсран гүйцэтгүүлэхээр захирлын Б/26 тоот тушаал гаргасан байна. Тус тушаалаар хавсран гүйцэтгэх албан тушаалын цалин болох ТҮ-2 1,003,000 төгрөгөөс 40 хувь олгоогүй байна. Цалингийн 1 сарын зөрүү 19,600 төгрөгийг дутуу олгосон байна.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйл. 56.1.Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно.	Сул орон тоо гарсан албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тушаалыг Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлэн гаргаагүй байхад архив, бичиг хэргийн ажилтанд 205.2 мянган төгрөгийн нэмэгдэл хөлс илүү олгосон байна. Жижүүр, галч нарт 19.6 мянган төгрөгийг тус бүр дутуу олгосон байна.
Шалтгаан	
Байгууллагын дарга сул орон тоог хавсран ажиллах тухай хууль, тогтоомжийг мөрдөж тушаал гараагүй үйлдэл, эс үйлдэл	
Үр нөлөө	
Цалингийн зардал хэтрэх, төсвийг хэмнэлтгүй зарцуулахад нөлөөлсөн үр дагавартай.	
Дүгнэлт:	
Сул орон тоо гарсан албан хаагчийн албан үүргийг хавсран гүйцэтгүүлэх тушаалыг гаргахдаа, цалингийн зэрэглэлийг буруу тооцсон.	
Зөвлөмж:	
1. Орон тоо батлагдсан эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нэмэгдэл хөлс тооцон олгож байх.	

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр

Илэрсэн асуудал 1. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 2 гүйлгээ, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бодиттой байх шаардлагыг хангаж бүрэн мэдээлээгүй байна. Дотоод аудитын чиглэл: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт.	
Шалгуур үзүүлэлт:	Илэрсэн алдаа, дутагдал:
Шилэн дансны тухай хуулийн 6.3. Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна: 6.3.5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт; Шилэн дансны тухай хуулийн 6.4.Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;	• Үнэ төлбөргүй хүлээн авсан 22,758 мянган төгрөгийн үндлсэн хөрөнгийг мэдээлээгүй. • Тайлан хугацаанд 18 удаагийн 608,097.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ мэдээлэхээс 5 удаагийн 89,351.2 мянган төгрөгийн орлогыг мэдээлээгүй. • Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил үйлчилгээнээс 10 удаагийн 17,059.3 мянган төгрөгийг мэдээлээгүй. • Хөрөнгө мөнгө захиран зарцуулахтай холбоотой 8 удаагийн 12,649.9 мянган төгрөгийн тушаалыг мэдээлээгүй байна.

Шалтгаан	
Шилэн дансны шинэчилсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах аргачлал, зааврыг бүрэн хэрэгжүүлээгүй үйлдэл, эс үйлдэл.	
Үр нөлөө	
Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хууль, Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.	
Дүгнэлт: Тус байгууллага нь 2025 оны 3-р улирлын байдлаар шилэн дансанд 23 нэр төрлийн мэдээллийг 140 талбарт мэдээлэхээс хуулийн хугацаа хоцроож 1 талбарт мэдээлсэн, мэдээллийн үнэн зөв, бодиттой, иж бүрэн байх зарчмыг бүрэн хангасан байдлыг шалгахад 17 алдаа гаргасан байна	
Зөвлөмж:	
1. Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	

6.НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Дорнод аймгийн музейн 2025 оны III улирлын байдлаарх төсөв санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн алдаа, дутагдлын үр нөлөө, цаашид үүсэх эрсдэлийг үнэлээд дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Аудитаар илэрсэн алдаа дутагдалыг залруулах, аудитын тайлангаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг цаглаварт хугацааны дотор ХШҮДАГ-т албан бичгээр хавсарган ирүүлэхийг мэдэгдье.

7. ЗӨВЛӨМЖ

Төсвийн шууд захирагч, захирал В.Нарангэрэл танаа		Хугацаа
Зөвлөмж 1.	Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан, тайлангаар илэрсэн алдаа дутагдлыг залруулан, үр дүнг хамт олонд мэдээлж байх;	2025 оны 12-р сарын 25-ны дотор
Зөвлөмж 2.	Орон тоо батлагдсан эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нэмэгдэл хөлс тооцон олгож байх.	
Нягтлан бодогч Л.Эрдэнэсүвд танд		
Зөвлөмж 1.	Шилэн дансны тухай хуулийн мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх;	2025 оны 12-р сарын 25-ны дотор

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ